

ХҮРД ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДУГНЭЛТ

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэнд талархаж, хурлын ажиллагаанд идэвхтэй, ажил хэрэгч оролцохыг хүсч байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг өдөр тутмын 2 тогтмол хэвлэл /Өдрийн сонин, Үндэсний шуудан/, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг Улаанбаатар телевиз, Монголын үндэсний олон нийтийн радиогоор 2 удаа зарлаж, Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээллээ.

Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчдийн тоо болон хувь хэмжээнд бага зэргийн өөрчлөлт, хөдөлгөөн гарсан ч 2018 оны 02-р сарын 23-ны байдлаар компанийн 135266 ширхэг хувьцааг 103 хүн эзэмшдэг хэвээрээ байна.

Тайлант хугацаанд компанийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан бизнес төлөвлөгөө, удирдлагын зардал, компанийн үйл ажиллагаа, ажиллагсдын цалин хөлс урамшуулал, хөрөнгийн өсөлт бууралт, ногдол ашиг, удирдлагын урамшуулал олгох асуудалд анхаарал хандуулан ажиллаж ирлээ.

Компанийн ТУЗ 8 удаа хуралдаж, хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах, ногдол ашиг болон удирдлагын урамшуулал олгох, компанийн хэтийн хөгжил, засаглалыг сайжруулахад зориулж шинэ залуу боловсон хүчин бэлтгэх, инженерүүдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж зэрэг эзэмшүүлэх, бизнес төлөвлөгөөний биелэлт, компанийн үйл ажиллагааг өргөтгөх, барилга угсралтын ажлын явцтай танилцах шинэчлэх зэрэг асуудлуудыг шийдвэрлэлээ.

2016 онд компанийн нэгж хувьцаанд **755** төгрөг, бүгд **102.1** сая төгрөгийн ногдол ашиг олгосон бол 2017 онд компанийн нэгж хувьцаанд **497** төгрөг, нийт **67,227.2** мянган төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас 2016 оны ажлын үр дүнд "**хангалттай**" гэсэн дүгнэлт өгснийг үндэслэн удирдлагын урамшуулал олгох журмын дагуу ТУЗ болон удирдлагын урамшилд **30,0 сая** төгрөг олгожээ.

2017 оны компанийн удирдлагын зардлыг **261,3** сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэл нь **270.1** сая төгрөг болж, **8.3 сая** төгрөгийн хэтрэлттэй ажиллажээ.

Компани санхүүгийн хувьд мөнгөн хөрөнгө, материалын зохих нөөцийг бүрдүүлж, эдийн засгийн хүчин чадал өсөн нэмэгдэж байна.

Компанийн үл хөдлөх хөрөнгө өөрчлөлтгүй, **9** барилга байгууламж-**316,0** сая төгрөг хэвээр байна.

Үндсэн хөрөнгө оны эхэнд **1146,0** сая төгрөг байсан бөгөөд доорх өөрчлөлт орсон байна. Үүнд: **8,8** сая төгрөгийн өртөг бүхий тавилга, эд хогшил, компьютер, программ хангамжаар нэмэгдэж, оны эцэст **1154,8** сая төгрөг болж өсчээ.

Байгууллага хүмүүсээс авах БУА-ын санхүүжилт болон авлага оны эхэнд **2007,9** сая төгрөг байсан бол тайлант хугацаанд **5070,8** сая төгрөгөөр

нэмэгдэж, **4502,1** сая төгрөгөөр буурч, оны эцэст авлага **2576,6** сая төгрөг болж, авлага **568,7** сая төгрөгөөр өссөн байна.

Мөн байгууллага хүмүүст өгөх өглөг оны эхэнд **480,6** сая төгрөг байсан бол тайлант хугацаанд **727,9** сая төгрөгөөр нэмэгдэж, **837,0** сая төгрөгөөр буурч, оны эцэст **371,5** сая төгрөг болж өглөг **109,1** сая төгрөгөөр буурсан байна.

Бид өнгөрсөн онд **3** тэрбум **896** сая төгрөгийн БУА гүйцэтгэж, **3** тэрбум **562** сая төгрөгний зардал гаргаж, **334.0** сая төгрөгийн ашигтай, 1 төгрөгний БУА-ыг **91.4** мөнгөөр гүйцэтгэж, барилга угсралтын хувьд **8.6%** ашигтай ажиллажээ.

Компанийн нийт борлуулалт 2017 онд **4** тэрбум **691,8** сая төгрөг бөгөөд татварын өмнөх ашиг **780,3** сая төгрөг, үүнээс цэвэр ашиг **611.1** сая төгрөг байна.

Энэ онд улсын төсөвт төлөх НӨАТ, аж ахуйн нэгжийн ашгийн татвар, хүн амын орлогын татвар, үл хөдлөх хөрөнгийн, газрын, тээврийн хэрэгслийн татварт **152** сая төгрөг, мөн нийгмийн даатгалын шимтгэлд **143,9** сая төгрөг төлж, улсын татварын өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн байна.

Бид Монгол улсад Цахилгаан сантехник угсралтын мэргэжлийн байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойг өнгөрсөн онд амжилттай тэмдэглэн өнгөрүүлж, 80 жилийн түүхээ баатасан дурсамж номоо бүтээлзээ.

2017 онд мөнгөн хөрөнгийн ашиглалт, банкны хүүг нэмэгдүүлэх болон авлага, өглөгийг барагдуулах буюу эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд амжилттай ажилласан байна.

Компанийн ашиглалтгүй буюу илүүдэлтэй ажлын байруудыг түрээсээр ажиллуулж, 2017 онд **133,2** сая төгрөгийн түрээсийн орлого оруулсан нь өнгөрсөн оныхоос **44,4** сая төгрөгөөр өссөн байна. .

2016 онд ажлыг нь бүрэн хийж, ашиглалтад өгсөн хэд хэдэн томоохон барилгын санхүүжилтын **980,5** сая төгрөг одоо хүртэл олгогдоогүй, хэдийд олгох нь тодорхойгүй байна.Үүнд:

-Баруун-Уртын Элит хорооллын инженерийн шугам сүлжээ -804,9 сая ₮
-1-р хороолол Орбитын чиглэлийн цэвэр усны шугамын эх үүсвэрийн хаалттай дэд өртөөний тэжээлийн кабель шугам-175,6 сая төгрөг

Компанийн үйл ажиллагаа, эдийн засгийн үзүүлэлт, 2017 оны бизнес төлөвлөгөөний биелэлт, ТҮЗ-ийн үйл ажиллагаа тогтвортжсон зэргээс хараад компанийн ТҮЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хэвийн явагдаж, үүргээ биелүүлж ажилласан гэж үзэж байна.

2018 онд компанийн зорилtot үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Энэ оны ажлын ерөнхий чиглэл, зорилго дараах байдалтай байна. Үүнд:

2018 онд Бизнес төлөвлөгөөгөөр **7,268** тэрбум төгрөгийн борлуулалт, **667,3** сая төгрөгийн ашигтай байхаар төлөвлөсөн.

2018 онд барилга угсралтын ажлаа гүйцэтгэхээс гадна компанийн гадаад харилцааг хөгжүүлэх, гадаадын түнштэй хамтарсан сантехникийн материалын худалдаа эрхлэх, барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах, орон сууц барих ажлыг үргэлжлүүлэх бодлого боловсруулж ажиллана.

Компанийн үйл ажиллагааг өргөтгөж, 2017 оны 01-р сараас Баянзүрх дүүргийн 14-р хороололд Дулаан дамжуулах 4 төв, 2448 айлын 10000 орчим хүн амьдрах орон сууцны цогцолбор хотхоны ус, дулааны ашиглалтыг хариуцан ажиллах “Хүрд-Орон сууц” салбарыг бий болгоод байна. Энэ салбарыг ажиллуулахаар Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний тусгай зөвшөөрөл шинээр авч одоогоор 20 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

Мөн барилгын зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах тусгай зөвшөөрөл авч, зураг төслийн алба байгуулахаар шинээр 3 инженер ажилд аваад ажиллаж байна.

Компанийн бетон эдлэлийн болон төмөр хийцийн цехийг бие даасан үйлдвэр ХХ Компани болгосон. Тэд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бие даасан ажиллагааг хэрэгжүүлэх, ашигтай ажиллах шаардлагатай боллоо.

2017 онд Баянзүрх дүүргийн 30 машины гаражийн барилгын суурин дээр баригдах цэцэрлэг бүхий 15 давхар 98 айлын орон сууцны 16 давхар барилгын карказ цутгалтын ажлыг гүйцэтгэлээ.

2017 онд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн түвшинд явагдаж, санхүүгийн тогтвортой байдлаа хадгалж, төлөвлөгөөт зорилтуудаа амжилттай биелүүлснийг харуулж байна.

Хэдийгээр компани 2017 онд зохих ашигтай ажилласан боловч цаашид үүсч болох хүндрэл, санхүү хөрөнгө оруулалтын эрсдэлээс сэргийлэн хэмнэлтийн хатуу горимд ажиллах шаардлагатай байна.

Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд 1 хүн сонгон ажиллуулах шаардлагатай байна. ТУЗ-ийн бусад гишүүд, гүйцэтгэх удирдлагын бүрэлдэхүүнд өөрчлөлт байхгүй тул улируулан үргэлжлүүлж ажиллах саналтай байна.

Компанийн 2017 оны удирдлагын зардлын зарцуулалтыг үндэслэн 2018 оны удирдлагын зардлыг **300,0 сая төгрөгөөр** төлөвлөж байна.

Ажлын үр дүн, компанийн 2017 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд хангалттай гэсэн дүгнэлтийг компанийн төлөөлөн удирдах зөвлөл өгч хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Мөн 2018 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлуулахаар хуралд хэлэлцүүлж байгаад санал бодлоо илэрхийлж баталж өгөхийг хүсье.

Та бүхэнд эрүүл энх, ажлын амжилт хүсэн ерөөе.

Хүрд ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл
2018.02.28